

БИ ХЭН БЭ?

46 ДАХИН ТӨРӨХӨӨСӨӨ ӨМНӨ

46.1 ЖИНХЭНЭ БАЙДАЛ

Бурханы үгийг сонсдог ч сонсож чаддаггүй.

Үргэлж сурдаг, гэхдээ хэзээ ч сурдаггүй.

⁴²Есүс тэдэнд -Хэрэв Бурхан та нарын Эцэг байсан бол, та нар Намайг хайрлах байсан. Учир нь Би Бурханаас гарч ирсэн билээ. Өөрийн санаагаар ирээгүй, харин Тэр Намайг илгээсэн юм. ⁴³Миний юу хэлж байгааг та нар яагаад ойлгохгүй байна вэ? Яагаад гэвэл та нар Миний үгийг сонсож чадахгүй байна. ⁴⁴Та нар эцэг чинь болох диаволаас гаралтай. Та нар эцгийнхээ хүслийг хийхийг хүсдэг. Тэр чинь эхнээсээ алуурчин байсан бөгөөд үнэн дотор зогсдоггүй. Учир нь түүнд үнэн байдаггүй. Тэр худал хэлэхдээ, чухам өөрөөсөө хэлдэг. Учир нь тэр худалч бөгөөд худал хуурмагийн эцэг нь юм. ⁴⁵Харин Би үнэнийг хэлдэг тул та нар Надад итгэхгүй байна. ⁴⁶Намайг нүгэлтэй гэх хүн та нарын дотор байна уу? Хэрэв Би үнэнийг хэлдэг бол та нар яагаад Надад үл итгэнэ вэ? ⁴⁷Бурханы хүн нь Бурханы үгсийг сонсдог. Та нар Бурханых биш учир эдгээрийг сонсдоггүй гэлээ. (Иохан 8:42-47 АБ 2004)

⁴Энэ үеийн бурхан үл итгэгчдийн бодол санааг сохолсон учраас тэд Бурханы дүр болох Христийн алдрын сайн мэдээний гэрлийг үзэж чадахгүй болжээ. (2 Коринт 4:4 АБ 2004)



[] Бурхан Есүсийг илгээсэн гэдэгт та итгэдэг үү?

[] Бурхан тантай Библийн үгсээр дамжуулан ярьж байгааг сонсож байна уу?

[] Бурханы үгийг сонсоход тань юу саад болж байгааг та мэдэх үү?

Үгээр удирдуулсан амьдрал

Дэлхийд удирдуулсан амьдрал



43.2 БУРХАНТАЙ харилцах харилцаанд нүгэл нөлөөлдөг

- Хүссэн зүйлээ өөрийн замаар хийх нь Бурханы арга зам биш юм.
- Нүгэл нь Бурхан та хоёрыг тусгаарладаг.
- Аливаа зүйлийг өөрийнхөөрөө хийх нь Бурханы ажил биш.
- Аливаа зүйлийг Их Эзэн дотор өөрийн арга замаар хийх нь Бурханы ажил биш.
- Итгэл үнэмшилгүй, Бурханы үггүй аливааг хийх нь нүгэл.
- Бурханы алдрыг харуулдаггүй харин хүний алдар сууг харуулсан үйл нь Бурханы ажил биш; дэмий хоосон зүйл юм.

²Номлогч,

“Бүгд хоосон, хоосны хоосон болой” гэв.

³Наран доор ажиллагч хүмүүний бүх хөдөлмөрийн үр ашиг нь юу вэ? ⁴Нэг үеийнхэн явж нөгөө үеийнхэн ирсээр байвч Дэлхий ертөнц үүрд үлддэг. (Номлогчийн үгс 1:2-4 АБ 2004)

¹²“Тэгэхээр Израиль аа, Би чамд ийнхүү хийнэ. Би чамд үүнийг хийх учраас Израиль аа, өөрийн Бурхантайгаа уулзахад бэлтгэгтүн”. (Амос 4:12 АБ 2004)

Хэрэв дэлхий дээрх бүх зүйл нь цаг хугацааны төгсгөлд нийтийг хамарсан түймрийн түлш нь болдог бол, тэдгээрийг олж эзэмшихийн хэрэг юу байх вэ?

[] Бидний цаг хугацаанаас цааш юу үргэлжлэхийг та мэдэх үү?

ХУВЬ ЗАЯА**46.3 Гэм нүглийн боол ба үхлийн хөлс**

¹⁵Тэгвэл яах вэ? Бид хуулийн дор бус, харин нигүүлслийн дор байдаг учраас нүгэл үйлдэх үү? Бүү ийм байх болтугай! ¹⁶Та нар өөрсдийгөө дуулгавартай байхаар боол болгон хэн нэгэнд өгөхдөө, үхэлд хүргэх нүглийн ч бай, эсвэл зөвт байдалд хүргэх дуулгавартай байдлын ч бай, дагах нэгнийхээ боол нь болдгоо мэдэхгүй гэж үү? ¹⁷Харин Бурханд талархал нь байг. Учир нь та нар нүглийн боолууд байсан боловч та нар өөрсдөд чинь өгөгдсөн уг сургаалын хэв маягт зүрхнээсээ дуулгавартай болж, ¹⁸нүглээс чөлөөлөгдөн зөвт байдлын боолууд болсон. ¹⁹Та нарын махан бие сул дорой тул би хүний ёсоор хэлье. Та нар өөрсдийн эрхтнүүдийг ёс бус явдалд хүргэх цэвэр бус, ёс бус байдалд боол болгон өргөснийхөө адил түүнчлэн одоо өөрсдийн эрхтнүүдээ ариусгалд хүргэх зөвт байдалд боол болгон өргө. ²⁰Учир нь та нар нүглийн боол байхдаа зөвт байдлаас чөлөөтэй байжээ. ²¹Тэгэхэд та нар одоо ичиж байгаа зүйлсээс ямар үр жимс авсан бэ? Учир нь тэдгээр зүйлсийн төгсгөл бол үхэл болой. ²²Харин одоо нүглээс чөлөөлөгдсөн бөгөөд Бурханд боолчлогдсон та нарт ариусгалд хүрэх үр жимс авдаг. Төгсгөл нь мөнх амь болой. ²³Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ Есүс доторх мөнх амь мөн.(Ром 6:15-23 АБ 2004)

[] Та нүгэлд удирдуулж, хийх зохисгүй гэж мэддэг зүйлсээ хийдэг үү?

[] Нүглийн боолууд нь мөнх амийн үр жимсийг биш нүглийн үр жимс ургуулдаг гэдгийг та мэдэх үү?

[] Та нар оюун ухаан, бие махбодоо цэвэр байлгаж чадах уу? Та авралынхаа талаар сайрхдаг уу?

46.4 Гэм нүглийн үр дагавар

¹⁸Бурханы уур хилэн үнэнийг зөвт бусаар нуун дарагч хүмүүсийн аливаа бурханлаг бус ба зөвт бус байдлын эсрэг тэнгэрээс илчлэгддэг. ¹⁹Учир нь Бурханы тухай мэдэж болох зүйл тэдний дунд илэрхий байдаг юм. Учир нь Бурхан тэдэнд ил болгосон аж. ²⁰Ертөнц бүтээгдсэнээс хойш Түүний үл үзэгдэх чанарууд,

Түүний мөнх хүч ба бурханлаг төрх нь бүтээгдсэн зүйлсээр дамжуулан ойлгогдон, илэрхий харагдаж байгаа. Иймээс тэдэнд шалтаг байхгүй.²¹ Яагаад гэвэл тэд Бурханыг мэдсэн атлаа Бурхан хэмээн Түүнийг алдаршуулсан ч үгүй, Түүнд талархал өргөсөн ч үгүй. Харин тэд бодол санаандаа хоосорч, мунхаг зүрх сэтгэл нь харанхуй болжээ.²² Мэргэн гэж хэлдэг атлаа тэд мунхаг болсон бөгөөд²³ үл муудагч Бурханы алдрыг мууддаг хүн, шувууд, дөрвөн хөлт амьтад хийгээд мөлхөгчидтэй адил дүрээр сольжээ.²⁴ Иймээс Бурхан тэднийг зүрх сэтгэлийнх нь хүсэл тачаалын бузар юмстай нь зөнд нь орхиж, тэднийг өөрсдийнхөө махан биеийг гутаахад хүргэжээ.²⁵ Яагаад гэвэл, тэд Бурханы үнэнийг худал хуурмагаар сольж, Бүтээгчээс илүү бүтээлд нь мөргөн, зарагджээ. Бурхан бол үүрд магтагдах Бүтээгч мөн. Амен.

- ⁶Ийм учраас Бурхан тэднийг гутамшигт хүсэл тачаалтай нь зөнд нь орхижээ.

Тэдний эмэгтэйчүүд ч бэлгийн төрөлх харьцааг төрөлх бусаар сольцгоожээ.²⁷ Түүнчлэн эрчүүд ч эмэгтэй хүнтэй бэлгийн төрөлх харьцаатай байхаа орхиод, нэг нэгэндээ тэмүүлэх хүсэлдээ шатаж, эрчүүд эрчүүдтэйгээ ичгүүрт зүйлийг үйлдэж, өөрсдийн алдааны зохих цээрлэлийг өөрсдөдөө хүртэж байна.²⁸ Тэд Бурханыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан учраас

- Бурхан тэднийг завхарсан сэтгэлтэй нь зөнд нь орхиж,

хийх ёсгүй зүйлсийг үйлдэхэд хүргэсэн бөгөөд²⁹ тэд бүхий л зөвт бус байдал, хорон муу, шунал, бузар булайгаар дүүрэн, атаа жөтөө, аллага, хэрүүл, заль мэх, хар санаагаар дүүрэн, хов жив яригч,³⁰ гүтгэгч, Бурханыг үзэн ядагч, дээрэлхүү, их зантай, сагсуу, хорон мууг санаачлагч, эцэг эхдээ дуулгаваргүй,³¹ ухваргүй, найдваргүй, үл хайрлагч, өршөөл үзүүлдэггүй хүмүүс ажээ.³² Ийм зүйлсийг үйлдэгч нь үхвэл зохино гэсэн Бурханы зарлигийг тэд мэддэг хэрнээ өөрсдөө үйлдээд зогсохгүй, харин ч бусдыг үйлдэхэд нь сайшаадаг ажээ. (Ром 8:18-32)

[] Бурханы бичигдсэн уур хилэнгээс хэрхэн зайлсхийх зааврыг та мэдэх үү?


[] Ариун бусыг хэрхэн ариун болгох,шударга бусыг хэрхэн зөвт болгохыг мэдэх үү ?

[] Ертөнцөд ёс бус явдлын ерөнхий түвшин яагаад улам нэмэгдэж байгааг та мэдэх үү?


[] Бузар тачаалаас юу үүсдэгийг та мэдэх үү?

<http://www.worldmapper.org/>


Исламын шашин 1.9 тэрбум (24.7 %)




Христийн Протестант 545.9 сая (7.9 %)




Католик 1.329 тэр бум




Еврейн шашин 14,064,440




Буддын шашин 1,222,710,333



Шашингүй 918,173,420





Шашин тус бүрт харгалзах хүний тоо


https://en.wikipedia.org/wiki/List_of_religious_populations



46.5 Нас баралтын шалтгаан 1900 он ба 2010 он

<https://www.theatlantic.com/health/archive/2012/06/хүснэгт-тэрүедбаодооцагтхүмүүсийгюухөнөөсөн/258872/>


Вашингтон Постын Сара Клифийн Шинэ Английн сэтгүүлээс авсан хүснэгтэд хүмүүсийн нас барсан өдгөөгийн шалтгааныг нэг жилийн өмнөхтэй харьцуулжээ.



Уг хүснэгтэд жил бүрийн тохиолдсон үхлийн эхний арван шалтгааныг жагсаасан. Мөнх бусыг үзэх тохиолдол буурсан ч, америкчуудын нас баралтын тэргүүлэх хоёр шалтгаан нь зүрх судасны өвчин, хорт хавдар байсан. 1900 онд хорт хавдар, зүрхний өвчний шалтгаан нь нийт нас баралтын 18%-ийг эзэлж байсан бол өдгөө 63% болтлоо өссөн аж. Нийт үхлийн шалтгаанд зонхилохоос гадна эдгээр өвчнөөр нас барагсдын тоо 1900 онд 100000 хүнд 201 байснаас өдгөө 380 болсон байна.

46.6 Нас баралтын шалтгаан (ДЭМБ)

Нас баралтын шалтгаан (Дэлхийн түвшинд нэг жилийн(2016) байдлаар)



46.7 Өдөрт 153 мянган хүн нас бардаг

<http://www.tebyan.net> (өдөр бүр 150,000 гаруй хүн нас бардаг)

(http://www.hebrew4christians.com/About_HFC/Death_Rate/death_rate.html)

Дэлхийн эргэн тойронд хүмүүсийн (мөн бидний мөнх бус байдал) мөнх бусыг үзэж байгаа байдлын талаар авч үзэх нь эн тэргүүнд

тавих зүйлс дээрээ илүү хичээнгүйлэн тунгаан бодоход чиглүүлж, зорилгоо ухамсарлахыг сануулдаг.

Статистикчдийн тооцооллоор дэлхийн хүн амын"нас баралтын түвшин"- ойролцоогоор . 883 хувь гэсэн байдаг. Энэ нь дэлхийн 113 хүн тутмын нэг нь жилийн дотор нас барж байгаа гэсэн үг.

Энэ үзүүлэлтэд үндэслэн тооцооллыг авч үзвэл одоо амьдарч байгаа хүмүүсийн нас баралтын тохиолдол :

Өдөрт 153 мянган хүн, жилд 6.0 сая хүн нас бардаг.

Амьдралын дундаж наслалтын хугацаанд (70 жил) 3.9 тэрбум хүн нас барсан байдаг.

Эдгээр тоо нь индуктив дээр суурилдаг ерөнхий ойлголтын хувьд алдаа мадагтай байж болох хэдий ч, хүмүүс үхэж байгаа нь бодит байдал хэвээр байна. Бидний эргэн тойронд байгаа эдгээр хүмүүсийн ихэнх нь Израилийн ЭЗЭН Бурханы Хүү Иешуагаар дамжин ирэх авралын тухай сонсоогүй байдаг. Эдгээрээс үзвэл үхэл рүүгээ явж байгаа хүмүүст бид Эзэн Есүс Мессиагийн сайн мэдээг түгээхээс өөр замгүйгээр зүрх сэтгэлдээ хөглөгдөн хөдлөх ёстой.


ДЭМБ-ын 4-Р ДЭВТЭР 46([http:// www.hebrew4christians.com](http://www.hebrew4christians.com))

¹⁷Харин чи сайн мууг мэдүүлэгч модны жимснээс огт идэж болохгүй. Чи түүнээс идсэн тэр өдөртөө л зайлшгүй үхнэ! хэмээн айлдав. (Эхлэл 2:17 АБ 2004).

⁶Тэр надад-Биеллээ. Би бол Альфа ба Омега, Эхлэл ба Төгсгөл. Цангасан нэгэнд Би амийн усны булгаас үнэгүй өгнө. ⁷Ялагч нь эдгээр зүйлийг өвлөх бөгөөд Би түүний Бурхан болж, тэр Миний хүү болно. ⁸Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхай хүмүүс, мэргэ төлөгчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалч хүмүүсийн хувьд, тэдэнд оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуурт байна гэв. ⁴Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо. (Илчлэлт 21:6-8 АБ 2004).

⁴Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо. (Илчлэлт 21:4 АБ 2004).

Цаг хугацаа, амьдрал аль аль нь нэг зүгт тэмүүлж, алийг нь ч зогсоох боломжгүй. Есүс Христийн сайн мэдээг сонсох, хүлээн авах нь авралд хүргэх цорын ганц зам. Төөрсөн сүнснүүдийн төлөө та зүрхнээсээ гашуудаж, залбирдаг уу ?



File: Inglehart Values Map. SVG

https://en.wikipedia.org/wiki/File:Inglehart_Values_Map.svg

46.8 Мөхөх ялтай бурхадтай

¹Чи тэдэнд “Тэнгэрүүд ба газрыг бүтээгээгүй бурхад газар дэлхийгээс болон тэнгэрүүдийн доороос устах болно” гэж хэл. (Иеремиа 10:11 АБ 2004)

Хуурамч бурхдыг дагадаг бүхэн ба тэдний хүч чадал хамтдаа явдаг. Энэ бурхадад 3 нийтлэг зүйл байдаг : миний төлөө, тэд зөвхөн одоод л үйлчилдэг болохоос ирээдүйд үйлчилдэггүй мөн зөвхөн энэ дэлхий дээр л байдаг.

[] Дэлхийн хуурамч бурхадын заль мэхийг та мэддэг үү?

46.9 ДАЙСНЫ ЗАЛЬ МЭХ

¹ЭЗЭН Бурханы бүтээсэн аливаа хээрийн зэрлэг амьтдын дотроос могой хамгийн илүү зальтай байжээ. Тэр могой -Та нарт энэ цэцэрлэгт байгаа бүх модны жимснээс идэж болохгүй гэж Бурхан үнэхээр хэлсэн үү? хэмээн эмэгтэйгээс асуужээ. ²Тэр эмэгтэй могойд хандаж -Бид энэ цэцэрлэг дэх модны жимснээс идэж болно. ³Харин цэцэрлэгийн голд байгаа модны жимсний тухайд Бурхан “Та нар түүнээс бүү ид, бас түүнд бүү хүр, тэгвэл та нар үхнэ” гэж айлдсан хэмээжээ. ⁴Тэр могой эмэгтэйд -Та нар ерөөсөө үхэхгүй. ⁵Та нар түүнээс идсэн тэр өдөртөө л нүд чинь нээгдэн, Бурхан шиг болж, сайн мууг мэдэх болно гэдгийг Бурхан мэддэг билээ гэжээ. (Эхлэл 3:1-5 АБ 2004)

⁴Нүгэл үйлддэг хүн бүр бас ёс бус хэрэг үйлддэг. Нүгэл бол ёс бус хэрэг юм. ⁵Нүглүүдийг зайлуулахын тулд Тэр үзэгдсэн гэдгийг та нар мэднэ. Түүнд ямар ч нүгэл байхгүй. ⁶Түүний дотор байгч хэн ч нүгэл үйлддэггүй. Нүгэл үйлддэг хэн ч Түүнийг үзээгүй, мэдээгүй. ⁷Бяцхан хүүхдүүд ээ, та нарыг хэн ч бүү мэхлэг. Зөвийг үйлдэгч нэгэн нь Түүний зөвт байгаачлан зөвт байна. ⁸Нүгэл үйлддэг нэгэн нь диаволынх юм. Диавол эхнээсээ нүгэл үйлдсэн. Диаволын үйлсийг устгахын тулд Бурханы Хүү энэ зорилгын төлөө үзэгджээ. ⁹Бурханаас төрөгч ямар ч хүн нүгэл үйлддэггүй.

Учир нь Бурханы үр түүний дотор байгаа. Тэр хүн Бурханаас төрсөн тул нүгэл үйлдэж чаддаггүй. (1 Иохан 3:4-9 АБ 2004)

[] Дайснаа хэн болохыг ялгаж мэдэх нүд, чих байна уу?

[] Төрөлх чанар нь нүгэлтэн учраас та нүгэл үйлддэг гэдгээ мэдэх үү?

[] Зөвт хүмүүс зөв шударгыг, хорон муу нэгнүүд нь бузрыг үйлддэгийг та мэдэх үү?

[] Бурханы Хүү Есүс яагаад ирсэнийг мэдэх үү?

46.10 Бурханы бүрэн хуяг дуулгыг өмс

¹¹Та нар диаволын заль мэхний эсрэг бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн хуяг дуулгыг өмс. ¹²Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд, тэнгэр дэх бузар муугийн сүнслэг хүчний эсрэг билээ. (Эфес 6:11:12 АБ 2004)

¹Та нар өөрсдийн нүгэл, хилэнц дотор үхсэн байв. ²Та нар урьд нь нүгэл, хилэнц дотор энэ ертөнцийн заншлын дагуу агаарын хүчний ноёрхогч буюу эдүгээ дуулгаваргүй хөвгүүд дотор ажиллаж буй сүнсийг дагаж явсан. ³Тэдний дунд бид ч бас бүгдээрээ урьд нь махан бие болон санаа бодлын хүслүүдээ өөгшүүлэн махан биеийнхээ хүсэл тачаалуудаар амьдарч байв. Мөн бусдын адил төрөлхөөс уур хилэн хүртэх хүүхдүүд байсан. ⁴Харин Бурхан өршөөлөөр баян Тэр биднийг хайрласан Өөрийн агуу хайраараа ⁵биднийг гэм нүгэл дотроо үхсэн байхад Христтэй хамт амьд болгосон юм. Та нар нигүүлслээр аврагдсан билээ. (Эфес 2:1-5 АБ 2004)

¹⁶Харин Сүнсээр яв, тэгвэл та нар махан биеийн хүслээ гүйцэлдүүлэхгүй гэж би та нарт хэлнэ. ¹⁷Учир нь махан бие Сүнсний эсрэг хүсдэг, Сүнс махан биеийн эсрэг хүсдэг юм. Яагаад гэвэл хүссэн юмсыг чинь хийлгэхгүйн тулд махан бие ба Сүнс нь нэг нэгнээ эсэргүүцдэг ажээ. ¹⁸Хэрэв та нар Сүнсээр удирдуулдаг бол Хуулийн дор байхгүй байна. ¹⁹Эдүгээ махан биеийн үйлс нь илэрхий юм. Эдгээр нь

завхайрал, бузар байдал, тачаангуй байдал,²⁰ шүтээн шүтэх, ид шид, дайсагнал, маргаан, хардалт, уур хилэн, өрсөлдөөн, хагарал, тэрс үзэл санаа,²¹ атаархал, архидалт, утга учиргүй наргиж цэнгэх зэрэг нь юм. Би урьд нь та нарт сануулж байсанчлан урьдчилан сануулъя. Ийм зүйлсийг үйлдэгчид нь Бурханы хаанчлалыг өвлөхгүй. (Галат 5:16-21 АБ 2004)

46.11 Өвөг дээдсээс өвлөж авсан нүгэл

- Өвөг дээдсийнхээ шийтгэлтэйгээр хорон муу хүчний засаглалын доор төрсөн

¹⁷Адамд хандан

-Чи эхнэрийнхээ үгийг сонсож, “Бүү ид!” гэж Миний чамд тушаасан модноос идсэн учир

Чамаас болж газарт хараал хүрч,

Чи насан туршдаа зүтгэж байж ургацыг нь идэх болно.

¹⁸Газар чамд зангуу ба халгайг ургуулна.

Чи тариалангийн талбайгаас ногоо идэх болно.

¹⁹Чи газар шороондоо эргэж очих хүртлээ

Духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ.

Учир нь чамайг газар шорооноос авсан.

Чи тоос шороо тул тоос шороондоо буцаж очих болно гэжээ.

(Эхлэл 3:17-19 АБ 2004)

⁵Чи тэдэнд мөргөж, тэдэнд үйлчилж болохгүй. Учир нь чиний Бурхан ЭЗЭН Би бол хартай Бурхан бөгөөд Намайг үзэн ядагчдын гурав, дөрөв дэх үеийн хүүхдүүдэд нь хүртэл эцгүүдийнх нь нүглийн шийтгэлийг буулгадаг. (Египштээс гарсан нь 20:5 АБ 2004)

²³Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ Есүс доторх мөнх амь мөн. (Ром 6:23 АБ 2004)

⁶Шударга зөв хүний ацаг хөлс нь амьдрал бол

Хар санаатны орлого нь шийтгэл. (Сургаал үгс 10:16 АБ 2004)

²¹Эцгүүдийнх нь буруугаас болж хөвгүүдэд нь цаазын тавцан бэлтгэгтүн.

Тэд босож, газрыг эзэмшиж,
ертөнцийн гадаргыг хотуудаар дүүргэх ёсгүй” (Исаиа 14:21 АБ 2004)

[] Адам яагаад унасныг та мэдэх үү?

[] "Уналт" нь үхэлд хүргэх хараалын хаалгыг нээснийг та мэдэх үү?

[] Нүглийн төлөөс, шийтгэлийг та мэдэх үү?

46.12 Үеэс үед

- Эцэг эхийн гурав ба дөрөв дэх үеийн нүглийн шүүлт

⁹Чи тэдэнд мөргөж, тэдэнд үйлчилж болохгүй. Учир нь чиний Бурхан ЭЗЭН Би бол хартай Бурхан бөгөөд Намайг үзэн ядагчдын гурав дөрөв дэх үеийн хүүхдүүдэд нь хүртэл эцгүүдийнх нь нүглийн шийтгэлийг буулгадаг. ¹⁰Харин Намайг хайрлаж, Миний тушаалыг сахигчдад мянган үед нь хүртэл хайр энэрлээ үзүүлдэг. (Дэд хууль 5:9-10 АБ 2004)

¹⁸“ЭЗЭН бол уурлахдаа удаан, хайр энэрлээр элбэг, гэм нүгэл, хууль бусыг уучилдаг. Харин Тэр гэм бурууг шийтгэлгүй орхидоггүй бөгөөд эцгүүдийнх нь гэм бурууг гурав, дөрөв дэх үеийн хүүхдүүдэд нь хүртэл буулгадаг”. (Тооллого 14:18 АБ 2004)

⁹Тиймээс хүн номхтгогдож, хүн басамжлагдсан ч гэсэн тэднийг бүү уучил. (Иеремиа 2:9 АБ 2004)

⁷Ингэхдээ та нарын хилэнц хийгээд та нарын эцэг өвгөдийн хилэнцийг хоёуланг нь хамтад нь төлнө” гэж ЭЗЭН айлдаж байна.

Учир нь тэд уулан дээр үнэртэн шатаан, толгод дээр Намайг доромжилсон.

Тиймээс Би тэдний урьдын үйлсийнх нь хэмжээгээр өвөрт нь буцааж төлнө”. (Исаиа 65:7 АБ 2004)

¹⁰Сайн сайхан яваарай гэж зөв хүмүүст хэлэгтүн.

Учир нь тэд өөрсдийнхөө үйлдлийн үр жимсийг идэх болно.

¹¹Хар санаатан золгүй ээ!

Муу муухай нь түүнтэй хамт байг!

Яагаад гэвэл тэр гарынхаа хувийг хүртэх болно. (Исаиа 3:10-11
АБ 2004)

[] « Та нар хойч үеийнхэндээ санаа тавьдаг уу?

Та тэдэнд ерөөлийн үүд хаалгыг нээж өгдөг үү? Та удамшлын
хараалыг яаж зогсоохоо мэдэж байгаа юу?

[] Бурхан яагаад хараал, ерөөлийг өвлүүлэх хууль гаргасныг та
мэдэх үү?